



МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах, сургалтын
төлбөрийн зээл олгох тухай


Өндөр хөгжилтэй орны магистрантурт суралцагчдыг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах ажлыг хариуцсан комиссын 1999 оны 7 дугаар сарын 8, 8 дугаар сарын 19-ны өдрүүдийн хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Өндөр хөгжилтэй орны магистрантурт суралцах 1999 оны уралдаант шалгалтад тэнцсэн Дашзэвэгийн Рэнцэнмядагийг химийн мэргэжлээр, Ванчиндоржийн Өлзийсайханыг мэдээлэл зүйн мэргэжлээр, Баянбатын Баясгаланг олон улсын эрх зүйн мэргэжлээр тус тус 2 жилийн хугацаагаар АНУ-ын Колорадогийн мэргэжлээр тус тус 2 жилийн хугацаагаар АНУ-ын Калифорнийн их сургуулийн засгийн мэргэжлээр АНУ-ын Калифорнийн их сургуулийн магистрантурт 1 жилийн хугацаагаар 1999/2000 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулсугай.
2. АУИС-ийн багш, Казакын анагаах ухааны их сургуулийн эчнээ аспирант Сэвжидийн Бадамжавт хамгаалалтын болон сургалтын зардалд зориулж эргэж төлөгдөх нөхцөлөөр богино хугацааны зээл, Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуулийг төгссөн Гүрбазарын Батбаярт мөн сургуулийн магистрантурт 1 жил суралцах зардал, УИХ-ын Тамгын газрын ажилтан Дамбажавын Ганболдод ОХУ-ын Дипломатын академид 2 жил суралцах хугацаанд тэтгэлгийн зээл, Лондоны Дипломатын академийн магистрант Бархасын Доржид нэг жилийн сургалтын төлбөр, АНУ-ын драмын урлагийн академийн магистрантурт суралцах Нарангэрэлийн Оргилд 2 жилийн зардал, Английн Кавентругийн их сургуулийн магистрантурт автомашины дизайны мэргэжлээр суралцах Тунгаагийн Эрдэнэчулуунд 1 жилийн зардал тус тус олгосугай.

3. Гэгээрлийн сайд, Санийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу дээрх хүмүүстэй гэрээ байгуулан холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Алтангэрэл/-д тус тус даалгасугай.



ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

 А. БАЛТОР